

Эхэд тулгуурлан багц даалгаврууд гүйцэтгэх тул доош гүйлгэн бүх даалгаврыг ажиллана уу!

Урмыг нь хугалахаар

Ууцыг нь хугал

Зандрангуй, шүүмжилж, уурлаж бусдад шаардлага тавих нь үүрэг хариуцлагыг дээшлүүлдэггүй болохыг Америкийн эрдэмтэн Р.Годдард судлан тогтоосон байдаг. Үглэж загнахыг хүн бүр чихний хажуугаар өнгөрөөж, бүр зарим тохиолдолд идэвх, оролдлого бууран ямар ч ажлыг хийж гүйцэтгэх хүсэл сонирхолгүй болох нь бий. Гэтэл үүний эсрэгээр хүн өөрийг нь магтвал таатай хүлээж авахаар барахгүй, мартдаггүй ажээ. Магтаал нь шан харамжаас ч илүү хүнийг идэвхжүүлэх хүчтэй гэж Годдарт тодорхойлсон байна. Гэхдээ магтаал худал, хоосон биш, яг гаргасан үйлдэл илрэлд таарсан, оновчтой байхын зэрэгцээ тухайн хүний онцлогт тохирсон байхад үр нөлөөтэй. Эс бөгөөс цагаа олоогүй, оновчгүй, хоосон магтаал эсрэгээрээ егөөдөл болж хувирдаг.

Ажил хэргийн харилцаанд удирдлагууд бусдыг байнга магтах, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид хүүхдийг сайшааж, онгиорох нь бас сайн зүйл биш бөгөөд үүнийг батлахын тулд Элиот Аронсон, Дарвин Линдер нарын эрдэмтэд Миннесотын их сургуулийн 80 оюутныг оролцуулан нэгэн туршилтыг явуулжээ. \Майерс.Д., 2007\ Долоон цуврал туршилтын нөхцөл буюу хөдөлмөрийн явцад судалгаанд оролцогчидтой зааварлагч 4 өөр зааврын дагуу дөрвөн бүлэг дээр ажилласан байна. Нэгдүгээр бүлгийн хувьд цуврал бүх л туршилтын явцад байнга магтах, хоёрдугаар бүлэгт байнга шүүмжлэх, гуравдугаар бүлэгт эхний хагаст шүүмжлэх, дараагийн хагаст магтах бол дөрөвдүгээр бүлэгт үүний эсрэгээр буюу эхний хагаст магтах, сүүлийн хагаст шүүмжлэх аргыг хэрэглэсэн ажээ. Туршилтын дараа шүүмжлэл, магтаалыг бус харин зааварлагчдыг үнэлүүлжээ. Хамгийн доогуур үнэлгээг эхлээд магтаад, дараа нь шүүмжилсэн зааварлагч авсан бол үүний дараах үнэлгээг байнга шүүмжлэгч, дараа нь байнга магтагч авсан ба судалгаанд оролцогчдын хувьд хамгийн ихээр таалагдсан зааварлагч эхлээд шүүмжлээд дараа нь магтсан байлаа.

Үүнээс дүгнэж үзэхэд цаг үеэ олсон шүүмжлэлийн дараа олсон амжилт ололт, ахиц дэвшлийн тухай магтаал хүмүүст хамгийн ихээр таалагддаг ажээ. Харин үндэслэлгүй, байнгын шүүмжлэл болоод бусдад уур, уцаараа гаргах нь “урмыг нь байтугай, ууцыг нь хугалахтай адил” болдог ажээ.

Г.Сарантуяа “Зүйр цэцэн үгийн сэтгэл зүйн тайлбар” 166-167 дугаар тал

Монгол хэлний даалгаврууд

1. Эхийн гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг сонгоно уу.
 - A. Үглэж загнахыг хүн бүр чихний хажуугаар өнгөрөөж, бүр зарим тохиолдолд идэвх, оролдлого бууран ямар ч ажлыг хийж гүйцэтгэх хүсэл сонирхолгүй болох нь бий.
 - B. Магтаал нь шан харамжаас ч илүү хүнийг идэвхжүүлэх хүчтэй гэж Годдарт тодорхойлсон байна.
 - C. Цаг үеэ олсон шүүмжлэлийн дараа олсон амжилт ололт, ахиц дэвшлийн тухай магтаал хүмүүст хамгийн ихээр таалагддаг ажээ.
 - D. Харин үндэслэлгүй, байнгын шүүмжлэл болоод бусдад уур, уцаараа гаргах нь “урмыг нь байтугай, ууцыг нь хугалахтай адил” болдог ажээ.

2. Эхийн **эхлэл төгсгөл хэсэгт** ямар санааг зохиолч давтсан байна вэ?
 - A. Хүнийг шүүмжилж, уурлаж зандрах нь заримдаа хүмүүст нөлөөлдөг.
 - B. Байнгын магтаал бус, зөв цагт өгсөн магтаал хамгийн үр дүнтэй байдаг.
 - C. Магтаал урам өгдөг ч шүүмжлэл бол засаж залруулах түлхүүр юм.
 - D. Үглэж зандрах, уурлах бус оновчтой магтаал нь хүнийг урамшуулдаг.
3. Дараах өгүүлбэрүүдийн алийг нь **зохиогч дэмжихгүй байх магадлалтай вэ?**
 - A. Магтаал бол сэтгэл зүйн урамшуулал юм.
 - B. Хүнийг зөвхөн магтах нь урамшуулах хамгийн сайн арга юм.
 - C. Зөв цагт өгсөн магтаал урам өгдөг.
 - D. Хэт хатуу шүүмжлэл сөрөг нөлөө үзүүлдэг.
4. Эхэд байгаа дараах өгүүлбэрүүдийг тохирох утгатай нь зөв харгалзуулсныг сонгоорой.

Өгүүлбэр

Үүрэг

1. Элиот Аронсон, Дарвин Линдер нар Миннесотын их сургуулийн 80 оюутныг оролцуулан туршилт хийсэн.”

A Баримт
2. “Магтаал нь шан харамжаас ч илүү хүнийг идэвхжүүлэх хүчтэй” гэж Годдарт тодорхойлсон байна.

B Үзэл бодол
3. Үглэж загнахыг хүн бүр чихний хажуугаар өнгөрөөж, зарим тохиолдолд идэвх, оролдлого буурдаг.

B Үзэл бодол
4. Туршилтын дараа зааварлагчдын талаар үнэлгээ авсан бөгөөд хамгийн доогуур үнэлгээг эхлээд магтаад дараа нь шүүмжилсэн багш авсан.
 - A. 1A, 2A, 3B, 4A
 - B. 1B, 2A, 3B, 4A
 - C. 1A, 2B, 3A, 4B
 - D. 1B, 2A, 3A, 4B
5. “Ажил хэргийн харилцаанд удирдлагууд бусдыг байнга магтах, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид хүүхдийг сайшааж, онгиороох нь бас сайн зүйл биш” гэсэн санааг батлах баримтыг сонгоорой.
 - A. А. Хамгийн доогуур үнэлгээг эхлээд магтаад, дараа нь шүүмжилсэн зааварлагч авсан
 - B. В. Доороосоо 2 дахь үнэлгээг байнга шүүмжилсэн зааварлагч авсан байв.
 - C. С. Доороосоо 3 дахь үнэлгээг байнга магтагч зааварлагч авсан байв.
 - D. Хамгийн ихээр таалагдсан зааварлагч эхлээд шүүмжлээд дараа нь магтсан байв.
6. Элиот Аронсон, Дарвин Линдер нарын эрдэмтэд Миннесотын их сургуулийн 80 оюутныг оролцуулан нэгэн туршилт хийх болсон шалтгаан юу вэ?
 - A. Оюутнуудын магтаалд хэрхэн хариу үйлдэл үзүүлдгийг судлахын тулд
 - B. Магтаал, шүүмжлэл нь хүний хандлагад хэрхэн нөлөөлдгийг батлахын тулд
 - C. Багш нарын заах арга барилыг үнэлэхийн тулд
 - D. Шүүмжлэлд оюутнууд хэр мэдрэг ханддагийг шалгахын тулд

7. Дараах холбоо үсгээс угсарсан нийлмэл үгийг олоорой.
 - A. хайр ба харуусал
 - B. санаа сэтгэл
 - C. Ширээн дээр
 - D. бага сургууль
8. Эхэд байгаа дараах баймж илэрсэн өгүүлбэрийг тохирох утгатай зөв харгалзуулсныг сонгоорой. /Нэг утга олон давтагдаж болно/

Баймж илэрсэн өгүүлбэр

Утга

- 1 Элиот Аронсон, Дарвин Линдер нар туршилт хийж, магтаал шүүмжлэлийн нөлөөг судалсан юм. **A** үгүйсгэсэн
- 2 Эцэг эх, багш нар хүүхдээ байнга магтах нь сайн зүйл биш.
- 3 “Магтаал нь хүнийг идэвхжүүлэх хүчтэй” гэж Годдарт тодорхойлсон байна. **B** баталсан
- 4 “Судалгаанд оролцогчдын хувьд хамгийн ихээр таалагдсан зааварлагч эхлээд шүүмжилж, дараа нь магтсан байлаа.”
 - A. 1B, 2A, 3B, 4B
 - B. 1A, 2A, 3B, 4A
 - C. 1A, 2B, 3A, 4A
 - D. 1B, 2A, 3A, 4B
9. “Үүнийг батлахын тулд Элиот Аронсон, Дарвин Линдер нарын эрдэмтэд нэгэн туршилтыг явуулжээ.” гэсэн өгүүлбэрийн утгыг зөв тодорхойлсныг сонгоорой.
 - A. Цагийн утгатай нийлмэл үг
 - B. Шалтгааны утгатай нийлмэл үг
 - C. Зорилгын утгатай нийлмэл үг
 - D. Орны утгатай нийлмэл үг
10. “Үндэсний их баяраар наадамчин олноо баясгахаар хүчит бөхчүүд барилдана” гэсэн өгүүлбэрт үг буруу хэлбэржүүлэх ямар алдаа гаргасан байгааг сонгоорой.
 - A. Өмнөө олон тооны нэр болон олны утгатай үг авсан жинхэнэ нэр олон тооны дагавраар хувилахгүй.
 - B. Өгүүлэхүүн нь бэлч, тарх, бөөгнө, барилд, уралд, багшир гэх мэт үйл үгээр илэрсэн байвал үйлийн эзэн болж байгаа жинхэнэ нэр олон тооны дагавар авахгүй.
 - C. Нэр үгэнд олон тооны дагаврыг давхарлан бичихгүй.
 - D. Үг давтсан тохиолдолд олон тооны дагавраар хувилахгүй.

Уран зохиолын даалгааврууд

11. “Гэсэрийн тууж”-д Цагаан гэрт хааны хүү Алтангэрэлт тайжид сайхан авгай авахын тулд “Балбын хааны охин сайхан уу?” хэмээн ямар амьтныг хэрхэн илгээдэг вэ?
- A. Уран дуут тотийг хоргойгоор тордож илгээдэг
 - B. Хон хэрээг муу сайн идээгээр бордож илгээдэг
 - C. Үзэсгэлэнт тогосыг жимсээр бордож илгээдэг
 - D. Харцагыг туулайн махаар тордож илгээдэг
12. “Гэсэр тууж”-д Гэсэр мэндлэх үедээ “Зүүн нүдээ харсан” нь ямар бэлгэдэлтэй вэ?
- A. Элээ шуламсыг тас хялайж буй нь тэр билээ.
 - B. Догшин шуламсын сүрийг тас залгиж буй нь тэр билээ.
 - C. Хамаг бүгдийг эзлэн барьж буй нь тэр билээ.
 - D. Энэ заяа, тэр заяа хоёрыг тэгш харж буй нь тэр билээ.
13. Б.Ринчений “Нууцыг задруулсан захиа” туужийн хэсэг нь аль хам сэдэвт тохирох вэ?
- Бүрхсэн бүхүй дуут хэнгэргээ
Бүгдийн дунд дэлдүүлнэ би
Харь манж цэргийг тэр дохиогоор
Хавчин хядаж хуримлана бид
- A. Түүхийн хам сэдэв
 - B. Соёлын хам сэдэв
 - C. Шашны хам сэдэв
 - D. Нийгмийн хам сэдэв
14. Хүнд хэцүү нөхцөл байдлыг сэтгэлийн тэнхээгээр даван гарч буй амьдралын тэмцэл аль зохиолын ямар дүрээр илэрдэг вэ?
- A. “Нууцыг задруулсан захиа”-Фү жанжин
 - B. “Үер”-Дэнзэн өвгөн
 - C. “Улаан хамбан зодогт”-Насан арслан
 - D. “Эвэр”- Ишиг
15. Д.Цэдэвийн “Улаан хамбан зодогт буюу тавын даваа” туужид Цоодол арслан “Ийм боорцог ч ахиад надад таарахгүй шүү” гэж хэнийг хэлсэн бэ?
- A. Түвдэндорж хүүг
 - B. Хүдэр даян аваргыг
 - C. Насан арсланг
 - D. Доной зааныг

Үндэсний бичгийн даалгаврууд

16. Монгол бичгийг кирилл бичигт зөв буулгасныг олоорой.

ᠰᠠᠭᠠᠯᠠᠭᠤᠨ
ᠰᠠᠭᠠᠯᠠᠭᠤᠨ
ᠰᠠᠭᠠᠯᠠᠭᠤᠨ

- A. Уучлал нь ихээ ухаарал бодлыг дагуулдаг.
- B. Уучлал нь их ухаарал бодлыг даалгадаг.
- C. Уучлал нь их ухаарал бодлыг дагуулдаг.
- D. Уучлалыг их ухаарал бодол дагуулдаг.

17. “Сэтгэл” хэмээх үгийг зөв бичсэнийг олоорой.

A
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

B
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

C
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

D
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

18. Зөв хариултыг олоорой.

ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ
?

A
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

B
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

C
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

D
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

19. Үгийг утгат хэсгээр задлаарай.

A
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ + ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

B
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ + ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

C
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ + ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

D
ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ + ᠰᠡᠲᠦᠭᠡᠯ

20. “Хуралдаан” үгийг зөв бичсэнийг олоорой.

A
ᠬᠤᠷᠠᠯᠳᠠᠭᠠᠨ

B
ᠬᠤᠷᠠᠯᠳᠠᠭᠠᠨ

C
ᠬᠤᠷᠠᠯᠳᠠᠭᠠᠨ

D
ᠬᠤᠷᠠᠯᠳᠠᠭᠠᠨ

